



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.08.05 № 47

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн
хэрэгжилтийн талаар

Засгийн газар, яам, агентлаг болон төрийн бусад байгууллагаас бүсчилсэн чуулган, форум, зөвлөгөөн, уулзалт зэрэг олон хүн оролцуулсан арга хэмжээг олноор зохион байгуулж байна. Жил бүрийн 8 дугаар сарын 01-ээс 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаа нь бүтээн байгуулалт, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх, өвөлжилтийн бэлтгэлийг хангах хамгийн хариуцлагатай үе юм. Энэ хугацаанд төрийн байгууллага төсөв, шатахуун, тээвэр, албан хаагчдын ажлын цагийг үр дүн нь тодорхойгүй арга хэмжээнд зарцуулах бус бодит ажлын талбарт төвлөрөх шаардлагатай байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулж түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэхээр заасан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 1.3-т байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах бөгөөд танхимаар, биечлэн хийх зайлшгүй шаардлагатайгаас бусад сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулахыг үүрэг болгосон байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангах асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Засгийн газар, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдээс 2026 оны 8 дугаар сарын 01-ээс 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан болон зохион байгуулахаар төлөвлөсөн бүсийн болон улсын хэмжээний чуулган, форум, зөвлөгөөн, хурал, уулзалт бүрийн нэр, огноо, байршил, зохион байгуулагч, оролцогчдын тоо, төрийн албан хаагчдын оролцоо, батлагдсан төсөв, санхүүжилтийн эх үүсвэр, томилолт, тээвэр, шатахууны зардал, зорилго, хэмжигдэхүйц үр дүнгийн нэгтгэсэн мэдээлэл;

2026000137

2.Дээрх арга хэмжээ тус бүр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.7, Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 1.3-т нийцэж байгаа эсэх, цахимаар эсхүл зардал багатай хэлбэрээр зохион байгуулах боломжгүй гэж үзсэн үндэслэл, уг шийдвэрийг гаргасан албан тушаалтны талаарх мэдээлэл;

3.Хууль, Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээгээр заавал зохион байгуулах, эсхүл гамшиг, осол, нэн яаралтай нөхцөлтэй холбоотой хойшлуулах боломжгүй арга хэмжээнээс бусад, төсөв, томилолт, тээвэр, шатахууны зардал шаардсан бүсийн болон улсын хэмжээний чуулган, форум, зөвлөгөөн, хурал, уулзалтыг 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл түр зогсоох шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангах;

4.Төлөвлөгдсөн арга хэмжээ бүрийг хэрэгцээ, хугацаа, өртөг, үр дүнгийн шалгуураар дахин хянаж, зайлшгүй шаардлагагүйг цуцлах, хойшлуулах, шаардлагатай хэлэлцүүлгийг цахимаар болон зардал багатай хэлбэрээр зохион байгуулах;

5.2026 оныг дуустал төлөвлөсөн, цуцалсан, хойшлуулсан болон цахим хэлбэрт шилжүүлсэн арга хэмжээний мэдээлэл, түүнчлэн хэмнэсэн төсөв, томилолт, тээвэр, шатахууны зардлын хэмжээг байгууллага тус бүрээр нэгтгэн олон нийтэд нээлттэй мэдээлж, асуулгын хариунд хавсаргах;

6.Цаашид төрийн байгууллагын чуулган, форум, зөвлөгөөн, хурал, уулзалтыг зайлшгүй хэрэгцээтэй, цөөн, зардал багатай, хэмжигдэхүйц үр дүнтэй зохион байгуулах нэгдсэн журам батлах. Уг журамд жил бүрийн 8 дугаар сарын 01-ээс 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зөвхөн хуульд заасан болон хойшлуулах боломжгүй арга хэмжээг зохион байгуулах, бусад арга хэмжээнд хэрэгцээний үндэслэл, оролцогчдын дээд тоо, зардлын хязгаар, цахимаар зохион байгуулах боломжийн үнэлгээ, үр дүнгийн шалгуур, олон нийтэд тайлагнах шаардлагыг тусгах.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.БАЯРМАА

2026000137